
Төгсбэлэгийн аялал



Ширэнгэн ойгоор аялсан нь

Зохиогч Том Кэлби



Эрхэм Бэлэг

Хэнээс:

_____

Хэнд:

_____




HANDS to the PLOW
MINISTRIES

handstotheplow.org

© "Hands to the Plow" корпораци, 1998
Нэмж шинэчилсэн хэвлэл © "Hands to the Plow" корпораци, 2000
"Hands to the Plow" корпорацид хэвлэв.
Webster, WI 54893, Ш/Х — 567
Конгрессын номын сангийн каталогийн картын дугаар: 00-110000
ISBN: 1-930914-01-6
Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү бүтээлийг хэвлэн нийтлэгчийн зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах, хэвлэн нийтлэх, цахим системд оруулах зэрэг янз бүрийн хэлбэрээр олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

Анхны хэвлэл - 1998
Нэмж шинэчилсэн хэвлэл - 2000
АНУ-д хэвлэв.

Төгсбэлэгийн Аялал





Ширэнгэн ойгоор аялсан нь

Зохиогч Том Кэлби
Зураач Марк Яагэр
Дизайнер Майкл Мэкон

ТӨГСБЭЛЭГИЙН АЯЛААД ТАВТАЙ МОРИЛ

Эрхэм уншигч таныг Төгсбэлэгийн аялал хэмээх энэхүү адал явдалт бяцхан ном уруу урьж байна. Та энэхүү номыг хүүхдүүдтэйгээ хамт уншиж байхдаа их баяртай байх болно гэдэгт итгэлтэй байна. Энд гарч буй олон сонирхолтой үйл явдлуудаар дамжуулан хүүхдүүд бүх хүнийг адилхан хайрладаг Үнэн Бурханы талаарх гайхамшигтай түүхийг мэдэж авах болно. Төгсбэлэгийн ширэнгэн ойн адал явдалт аялал нь энэ дэлхий дээр амьдарч буй бидний амьдралтай тун төстэй юм. Ингээд хүүхдүүдээ дагуулан энэхүү адал явдалт аяллаа эхэлцгээе.







өгсбэлэг бага байхдаа өвөөгийндөө үргэлж зочилдог байсан бөгөөд түүнийг очих бүрт өвөө нь Ширэнгэн ойн цаана орших хүчирхэг хаант улсын тухай олон гайхамшигт түүхийг ярьж өгдөг байжээ.

Өвөөгийнх нь ярьснаар тэр улсын хаан бусад хаадтай адилгүй байсан бөгөөд хүн нэг бүрийг өөрийн хүү, охин мэт хайрладаг байв. Бүх хүнийг маш сайн хайрлан халамжилдаг байсан учраас уг хаант улсад уйтгар гуниг, өвчин зовлон, үхэл хагацал гэж байдаггүй, үнэхээр төгс төгөлдөр улс байжээ.


Төгсбэлэг өвөөгийнх нь ярьж өгдөг байсан зүйлс үнэн эсэхийг мэдэхгүй байсан ч, он жил өнгөрөх тусам тэр бүгдийг үзэхсэн гэсэн хүсэл нь улам оргилон бадарсаар нэгэн өдөр өөрийн биеэр явж үзэхээр шийдэв. Гэвч Ширэнгэн ойг хэрхэн туулж гарах вэ гэсэн ганцхан асуулт түүнийг зовоож байлаа.



БАЛВГАЙ
УУР
ӨТГӨН
ТӨГӨЛ
ШҮРЭГЭН
ГОРХИ
НАМАГТ
ХӨНДИЙ
СӨНӨСӨН
УУРХАЙ
ТУУЛАЙН
НУХ
БОЛЗООТЫН
БОР ТОЛГОЙ
УСАН
САН
АНХААР
ХАДАН ХЯСАА
ӨВӨӨГИЙНХ
N

Төгсбэлэг ойн дунд өсөж том болсон хэдий ч гэрээсээ огт холдож үзээгүй байв. Гэвч зуны халуун өдрүүдэд найзуудтайгаа хамт явж усанд сэлдэг байсан бөгөөд нэгэн удаа Ойн цаадах хаант улсын барааг нь ч болов олж харахаар Өндөр уулын орой дээр гарч байсан удаатай.

Гэвч Төгсбэлэг Ширэнгэн ойн талаар аймшигтай зүйлсийг л хүмүүсээс сонсож байсан учраас ойн гүн уруу орох гэж нэг ч удаа зориглож байсангүй. Ойн гүнээс хачин сонин дуу авиа сонсогддог байлаа.


Тэр ой уруу орсон хүмүүсээс ихэнх нь гэртээ эргэж ирээгүй байв. Гэсэн хэдий ч ойг хамгийн шигүү, гүн хэсгээр нь нэвт гарч Ойн цаадах хаант улсад хүрэх ганц л зам байгааг Төгсбэлэг мэдэж байлаа.





Төгсбэлэг олон сар бодсоны эцэст Ойн цаадах хаант улс уруу явах аялалдаа гарлаа.

“Тийм ч аймаар биш юм шиг байна. Тун удахгүй зорьсон газартаа оччихно” хэмээн өөрийгөө тайвшруулан явж байв.





Төгсбэлэг ойн захад хүрээд, ганцаараа ямар нэгэн юм яриад, мод налан зогсож байсан нэгэн том биетэй хүнийг олж харав. Гэвч түүний хэлж байгаа үг Төгсбэлэгт сонсогдохгүй байлаа.


Төгсбэлэг “Уучлаарай, эрхэм ээ! Ойн цаадах хаант улсад яаж очихыг хэлж өгөөч. Би Хаантай уулзах гэсэн юм” гэлээ.




Тэр хүн урт, махир хуруугаараа Төгсбэлэгийн цээжийг чичин инээж, “Ха ха ха, чи тоглож байгаа байлгүй дээ. Ойн цаадах хаант улсад очиж Хаантай уулзахаар явж байгаа юм гэж үү? Тэр чамтай яах гэж уулзах юм бэ? Түүнд чиний хэрэг байхгүй.

Бие чинь хэтэрхий жижиг, нас чинь бага, бас чи хэтэрхий сул дорой юм байна. Хаан чам шиг ийм хүнтэй уулзахыг хүсэхгүй гэдгийг би бардам хэлж чадна шүү. Хаан чам шиг хүнтэй биш, зоригт дайчидтай л уулздаг юм” гэв.

“Хаан бүх хүнийг хайрладаг гэж өвөө маань хэлсэн шүү дээ” хэмээн Төгсбэлэгийг нулимс дуслуулан өгүүлэхэд өнөөх хүн улам чангаар инээж “Өвөө чинь буруу сонссон юм байлгүй дээ” хэмээн тохуурхаж, түүнийг хажуу тийш нь ярвайн түлхээд “Одоо миний замаас зайл. Надад чиний асуудлаас илүү бодох чухал зүйл их байна” гэв.






Төгсбэлэг тэр хүний хэлснийг үл хайхран Хаантай уулзах аяллаа цааш үргэлжлүүлэв. Аялал нь эхэндээ амархан байсан бөгөөд Ойн цаадах хаант улсад хурдан очихын тулд хамаг чадлаараа мэрийж явлаа.

Харамсалтай нь, ойн гүн уруу цаашлах тусам улам харанхуй болж, явахад хэцүү болж байв. Бүр заримдаа юу ч харагдахгүй болох үед тэрээр гараа урагш сунган, тэмтчин явж байв.





Төгсбэлэг харанхуйд гараараа тэмтчин явж байгаад дөрвөн хөллөн мөлхөж явсан нэгэн эрэгтэй хүнтэй мөргөлдчихөв. Тэрээр ямар нэг юм хайж байгаа бололтой байв. “Та юу хайж байгаа юм бэ?” хэмээн Төгсбэлэгийг асуухад “Би Ойн цаадах хаант улсад нэвтрэн орох зөвшөөрлийг хайж байна” гэж тэр хариулав. “Юу гэнэ ээ? Хаан бүх хүнийг хаант улсдаа оруулдаг гэж би бодсон шүү дээ” гэж Төгсбэлэг гайхан хэлэв.

Өнөөх хүн толгой сэгсрэн “Үгүй ээ, тусгай нэвтрэх зөвшөөрөл байхгүй бол Хаан чамайг өөрийн улсад оруулахгүй. Улсынх нь хууль тийм байдаг юм” гэв. “Тэр нэвтрэх зөвшөөрлийг хаанаас авч болох вэ?” гэж Төгсбэлэгийг асуухад “Уучлаарай, би өөрөө ч мэдэхгүй байна. Би гурван жил газар сайгүй хайгаад олоогүй л байна. Ер нь хайхаа больдог ч юм уу даа” гэж хариулав.

Төгсбэлэгийн урам хугаран, “Би ч буцсан нь дээр юм шиг байна. Тэр нэвтрэх зөвшөөрлийг нь хэзээ ч олж чадахгүй юм байна” гэж бодов.





Төгсбэлэг модны хожуул дээр суугаад уйлж эхлэв. Тэр юу хийхээ ч мэдэхгүй байлаа. Ойд хав харанхуй, бүр өмнө байгаа мод ч харагдахгүй байхад нэвтрэх зөвшөөрлийг олно гэдэг түүнд бүтэшгүй асуудал байв.

Яг тэр мөчид моддын дундуур нарны туяа нэвт тусан, нэгэн эмэгтэй тэр гэрэлд ил гарч ирэв. Тэр эмэгтэй маш номхон дөлгөөн харцтай байсан бөгөөд Төгсбэлэг хэдэн долоо хоног ойд явахдаа ийм хүнтэй огт тааралдаагүй билээ.

“Сайн уу?” хэмээн тэр мэндлээд Төгсбэлэгт дөхөж ирэв. “Би чиний уйлахыг сонсоод хар хурдаараа яарсаар ирлээ. Би чамд тусалж чадна” гэлээ.

Төгсбэлэг гунигтайгаар толгой сэгсрээд “Ирсэнд тань баярлалаа. Гэхдээ та надад тусалж чадахгүй байх аа. Би Ойн цаадах хаант улсад очихыг хүсэж байгаа ч, нэвтрэх зөвшөөрөл байхгүй учраас Хаан намайг оруулахгүй” гэв.






“Би тэр Хааныг мэднэ ээ” хэмээн эмэгтэй инээмсэглэн хариулаад “Түүний хаант улсад орох илүү нэвтрэх зөвшөөрөл надад байгаа. Чи авмаар байна уу?” гэж асуув. Төгсбэлэг “Тэгэлгүй яах вэ? Би авмаар байна” хэмээн халааснаасаа мөнгөө гарган тоолох зуураа сэтгэл догдлон хэлээд “Ямар үнэтэй юм бэ?” гэж асуулаа.

“Чамайг үнийг нь төлж дийлэхгүй байх вий гэж айж байна. Энэ бол үнэлж баршгүй зүйл шүү” гэж тэр хариулав.

“Тэгээд би яаж …” гэхэд нь эмэгтэй гараараа дохин үгийг нь таслаад “Үүнийг зүгээр л Хааны бэлэг гэж бодоод ав” хэмээн түүнд нэвтрэх зөвшөөрлийг өгөх зуураа хэлэв.

Төгсбэлэг “Би үүнийг үнэхээр авч болох юм уу? Зүгээр авч болох юм уу?” гэж асуухад эмэгтэй “Тэгэлгүй яах вэ! Хааны бүх бэлэг үнэгүй байдаг юм” гэлээ.

“Тэгвэл надтай ойд тааралдсан хүнд нэгийг аваачиж өгье! Тэр хүн гурван жил ийм нэвтрэх зөвшөөрлийг хайж байгаа гэсэн. Үнэгүй нэвтрэх зөвшөөрлийн талаар сонсоод тэр хүн маш их баярлана даа” хэмээн Төгсбэлэгийг уулга алдан хэлэхэд эмэгтэй толгой сэгсрэн “Хаан энэ зөвшөөрлийг түүнд өгүүлэхээр олон хүнийг түүн уруу илгээсэн билээ. Гэвч тэр биднийг худлаа ярьж байна гэж бодоод бидний үгэнд итгэхгүй байгаа юм. Төгсбэлэг ээ, чи нэвтрэх зөвшөөрлөө маш болгоомжтой авч яваарай. Үүнийг амь насаараа хамгаалах ёстой юм. Олон хүн үүнийг чамаас ямар ч хамаагүй аргаар авахыг хүсэх болно шүү” гэж хэлэв.





Төгсбэлэгийг хаант улсад нэвтрэн орох зөвшөөрлөө харан алмайран гайхаж байтал нөгөө эмэгтэй түүнд гар чийдэн өгөв.

“Энүүгээр яах юм бэ?” гэж Төгсбэлэгийг асуухад эмэгтэй “Энэ бол ер бусын гар чийдэн. Хаан үүнийг нэвтрэх зөвшөөрлийг авсан хүн бүрт өгдөг юм. Гар чийдэнгээ байнга асаалттай байлгах ёстой юм шүү. Унтрааж огт болохгүй. Ойн зам маш нарийн. Хэрэв чи үүнийг унтраах л юм бол төөрнө шүү” гэлээ.


Төгсбэлэг гар чийдэнгээ асаан моднууд уруу тусгав. Түүний эргэн тойронд байсан мод бүр гэрэлд тод харагдаж байлаа. “Ямар гоё юм бэ! Одоо явж байгаа газраа сайн харах боломжтой боллоо!” хэмээн тэрээр баярлан хэлэв.

Гэвч Төгсбэлэгийн баяр хөөр тэрхэн зуур алга болж, бодлогошрон “Зай нь дуусчихвал яах вэ? Ер нь үүнийг тас харанхуй газар л асаагаад, юм харагдахаар газар унтраагаад байж болох юм байна” гэж бувтналаа.

“Төгсбэлэгээ! энэ бол ер бусын, зай хэрэглэдэггүй гар чийдэн. Унтраалгүй хэрэглээд байвал гэрэл нь огт бүдгэрэхгүй. Харин үүнийг хэрэглэхээ больж, өөрийнхөө харах чадварт найдаж эхэлбэл гар чийдэнгийн гэрэл бүдгэрч, харанхуй газрыг ч гэрэлтүүлэхээ болино шүү. Үүнийг ямагт санаж яваарай” гэв.



“Гар чийдэнгийнхээ бүх хүчин чадлыг нь ашиглахын тулд байнга асаах хэрэгтэй. Тэр ч бүү хэл чи өөрөө замаа олж чадна гэж бодох үедээ ч үүнийг ашигла. Энгийн нүдээр харж чадахгүй олон зүйлийг энэ гэрэл чамд харуулах болно” гэж эмэгтэй нэмж хэлэв.



Төгсбэлэг эмэгтэйн зөвлөгөөг даган, гар чийдэнгээ байнга асаалттай авч явж байсан учраас амь насаа алдах аюулаас хэд хэдэн удаа зайлж чаджээ. Нэгэн удаа тэр гар чийдэнгийнхээ ачаар өмнөө байсан гүн нүхийг олж харан нүхэнд унах аюулаас аврагдав.

Мөн нэг удаа газар сууж амрах гэтэл суух гэсэн газарт нь том могой цагираглан хэвтэж байсныг гар чийдэнгийнхээ гэрэлд олж харав.

Төгсбэлэг ойд цааш явахаасаа өмнө урд нь аюултай зүйл байгаа эсэхийг гар чийдэнгээрээ шалгадаг болов. Гар чийдэнгээ тусган, замд нь ямар нэгэн саад бэрхшээл байхгүй болохыг мэдэж, итгэлтэйгээр цааш явж байлаа.








Нэгэн хүйтэн, харанхуй өдөр Төгсбэлэгийг ойд явж байтал зэвүүн муухай инээх дуу сонсогдов.

Хар хурдаараа зугтаахыг хүсэж байсан ч “Н-н-надад л тэгж санагдсан байх” гэж тэр ээрэн, өөрийгөө тайвшруулж байлаа.


Гэвч энэ нь зүгээр нэг хий хоосон зүйл биш, ямар нэгэн бодит зүйл болохыг тэр маш сайн мэдэж байлаа. Төгсбэлэг яг юу болохыг нь мэдэхгүй байсан ч өөрийг нь хараад байгааг ч мэдэрч байв.

“Гар чийдэнгээ унтраагаад, наашаа ирж надтай ярилцаач” гэж аяархан шивнэх дуу сонсогдов. Төгсбэлэг гар чийдэнгээ мод уруу, өнөөх дуу гарсан зүг уруу тусган гэрэлтүүлэхэд тэр амьтан муухай хашгираад нисэн одов. Ийнхүү гар чийдэн нь түүний амийг дахин аварчээ.





Дараагийн өдөр нь Төгсбэлэгийг цааш явах гэж байтал өрөөсөн нүд, биеийнх нь энд тэнд хавдаж хөхөрсөн нэгэн хүн арай ядан алхсаар хажууд нь ирэн, түүнд нэг сэлэм өгөөд "Хаан чамд үүнийг өгч байна. Тэр энэ сэлмийг чамд аль болох хурдан аваачиж өг гэлээ" хэмээн амьсгаагаа дарж ядан хэлэв. "Сэлэм ээ?" гэж Төгсбэлэгийг гайхан асуухад тэрээр "Энэ бол энгийн нэг сэлэм биш. Ер бусын сэлэм. Үүнийг хэрэглэх тусам хүч чадал чинь нэмэгдэнэ" гэв. "Энэ сэлмийг авах ёстой хүн нь би мөн юм уу? Яагаад Хаан надад энэ сэлмийг өгөхийг хүссэн юм бол? Би чинь эрэлхэг дайчин биш, зүгээр л нэг Төгсбэлэг шүү дээ" гэв.

"Хаан хүссэн учраас би үүнийг чамд өгөхийн тулд амь насаараа дэнчин тавьж тэмцсээр авч ирлээ. Түүний хувьд чи чухал хүн. Ямар ч бэрхшээл тохиолдсон үүнийг алдаж болохгүй шүү" гэхэд нь Төгсбэлэг "Би өмнө нь сэлэм огт хэрэглэж байгаагүй. Тэгээд ч энэ чинь маш том, хүнд юм байна" гэж учирлав.



“Чи үүнд санаа зовох хэрэггүй ээ. Хаан энэ сэлмийг чамд зориулж хийсэн юм. Чи үүнийг хэрэглэж эхлэнгүүтээ л өөрт чинь яг тохирсон болохыг нь ойлгоно. Хамгийн гол нь чиний дайсанд энэ сэлмээс чинь илүү хүчтэй зэвсэг байхгүй шүү. Энэ сэлмэнд агуу хүч оршдог юм” гэв.





Тэр хүн явахаасаа өмнө цүнхнээсээ жижиг зүйл гаргаж ирээд “Хаан үүнийг ч бас чамд заавал өгөөрэй гэсэн юм” гэлээ.

“Энэ юу вэ?” гэж Төгсбэлэгийг асуухад “Энэ бол харилцан ярилцах боломжтой радио холбоо. Чи үүнийг ашиглан Хаантай ярьж болно” гэж тэр хариулав.

Төгсбэлэг бүр гайхаж, “Хаан яагаад надтай ярихыг хүсэж байгаа юм бол оо? Би түүнтэй огт уулзаж байгаагүй шүү дээ. Та хүн андуурсан юм шиг байна аа. Би…би… ” гэж түгдчин хэлэв.

Нөгөө хүн толгой сэгсрээд “Би зөв хүнд өгч байгаагаа мэдэж байна. Хаан энэ радио холбоог чамд өгөхийг надаас онцгойлон хүссэн юм” гэв.


“Үүнийг яаж асаадаг юм бэ? ” гэж Төгсбэлэгийг радиогоо сонирхох зууpаа асуухад “Үүнд асаах, унтраах товчлуур байхгүй, байнга асаалттай байдаг юм. Зүгээр л ярь” гэж тэр хэлэв.

“Би үүнийг ямар үед ашиглах юм бэ? Надад аюул тохиолдсон үед үү? Би Хаанд төвөг удмааргүй байна” гэхэд нь өнөөх хүн инээн “Чи хичнээн их ярилаа ч Хаанд төвөг болохгүй. Чиний явж буй энэ өтгөн ой маш аюултай гэдгийг чи мартаж болохгүй. Ямар нэгэн юм тохиолдоход чинь Хаан чамтай ярьж зөвлөгөө өгөхийг хүсэж байгаа. Хаантай их л ярих тусам Хаан чамд илүү их туслах болно” гэв.


СЭЛЭМ
ХУДАЛДААНЫ ТӨВ

Тэдгээр сэлэмний ихэнхийг эрдэнийн чулуугаар чимэглэсэн байсан бөгөөд Төгсбэлэгийн гартаа барьж байсан энгийн сэлэмнээс илүү бат бөх мэт харагдаж байлаа. “Би … нөгөө … Хаан надад энэ сэлмийг өгсөн юм аа” гэж тэр түгдчив. “Хаан тусгайлан надад зориулж үүнийг хийж өгсөн” хэмээн түүнийг үргэлжлүүлэн хэлэхэд Сэргэлэн инээн “Чи арай үүнд нь итгээд байгаа юм биш биз дээ? Миний сэлэмнүүд хавьгүй илүү шүү. Чи надад өөрийнхөө сэлмийг өгөөд энэ сэлэмнүүдээс аваад үз” гэв.

Төгсбэлэг сэлэмнүүдийг нүд салгалгүй харсаар л байв. Үнэхээр сайхан сэлэмнүүд байлаа. Харин яагаад ч юм өөрийнхөө сэлмийг Сэргэлэнд өгмөөргүй санагдав. Тэрээр анх удаагаа радио холбоогоо гаргаж ирээд Хаантай ярив.



“Би Төгсбэлэг байна аа. Би Хаантай ярих хэрэгтэй байна. Гэхдээ Хаан завгүй байгаа бол төвөг удмааргүй байна” гэж хэлэв.


Төгсбэлэг хэсэг хугацаанд дуугаралгүй хүлээв. Тун удалгүй өмнө нь хэзээ ч сонсож байгаагүй хүчирхэг мөртлөө намуун зөөлөн дуу хоолой сонсогдов.

“Төгсбэлэг ээ! Би Хаан байна. Би чамд үргэлж цаг зав гаргана. Ярьсанд чинь би их баяртай байна. Чамд яаж туслах вэ?” гэх сонсогдлоо.

Төгсбэлэгийг “Өө, эрхэм ээ! Эрхэм дээдэс ээ! Би таны илгээсэн сэлмийг хүлээн авсан. Тэгээд … их сайхан сэлэм юм аа. Харин энд байгаа нэг хүн өөрийгөө миний сэлэмнээс илүү гоё сэлэмтэй, сэлмээ сольё гээд байна. Би яах вэ?” гэхэд Хаан намуун зөөлөн дуугаар “Төгсбэлэг ээ! Чиний барьж байгаа сэлмийг Ойн цаадах хаант улсад хийсэн юм. Чиний сэлэмд өөр ямар ч сэлэмд байхгүй их хүч шингэсэн байгаа. Олон дайчин амь насаараа дэнчин тавьж наад сэлмийг чинь чамд аваачиж өгсөн билээ. Наадах чинь яг л чамтай адил хэмжээлшгүй үнэ цэнэтэй зүйл” хэмээн хариулав. Хааны үгэнд урам зориг орсон Төгсбэлэг сэлэм зарж байсан хүнд хандан “Энэ сэлэм надад зориулагдсан тусгай сэлэм. Чиний түмэн сэлмээр ч би солихгүй” гэхэд “Өөрөө л мэд дээ. Сэлэм чинь хугарчихвал битгий над дээр ирээд уйлж унжаад байгаарай!” гэж тэр хариу хэлэв.


Төгсбэлэг “Санаа зоволтгүй ээ, энэ хугарахгүй” гээд замаа хөөн цааш одов.


СЭЛЭМ
ХУРДАЛДААНЫ ТӨВ



Төгсбэлэг ойд явж байхдаа радио холбоо, сэлэм хоёроо алхам тутамдаа ашиглаж, ач тусыг нь маш сайн ойлгов. Хаан түүнд радио холбоо, сэлмээс гадна ойд тохиолдох аюул заналаас өөрийгөө хамгаалахад нь хэрэг болох иж бүрэн хуяг, дуулгыг мөн өгчээ. Аяллаа эхэлснээс хойш олон сарын дараа Төгсбэлэг нэгэн өдөр том царс модны дэргэд хэсэг хүүхдүүд тоглож байгаатай тааралдав. Хамт аялах хүмүүсийг хайж байсан учраас Төгсбэлэг тэднээс “Та нар Ойн цаадах хаант улс руу аялж байгаа юм уу?” гэж асуухад хүүхдүүд тоглоомоо орхин түүнийг гайхан харав. Төдөлгүй нэгэн жижигхэн охин ам нээн “Ямар хаант улс вэ?” гэж асуухад Төгсбэлэг их гайхан “Та нар Ойн цаадах хаант улсыг үнэхээр мэдэхгүй гэж үү?” гэж асуулаа. Хүүхдүүд толгой сэгсрэв. Төгсбэлэг тэдэнд Хаан болон түүний улсын талаарх бүх л зүйлсийг ярьж өглөө.





Төгсбэлэг анх ойгоор аялж эхэлснээс хойш өөрт нь тохиолдсон бүхий л зүйлсийг тэдэнд ярьж өгөв. Хүүхдүүд түүнийг анхааралтай сонсоод олон зүйлийг лавлан асууж байлаа. “Бид энэ талаар өмнө нь огт сонсож байгаагүй” гэж өнөөх охин хэлээд “Хэрэв энэ үнэхээр үнэн юм бол чи яагаад хаант улс уруу яг одоо очихгүй байгаа юм бэ?” гэж асуув.

“Хаан бусад хүмүүст өөрийн улсын тухай ярихыг надад даалгасан юм. Би нэг л өдөр тэнд очно. Харин одоо би бусад хүмүүст замаа олоход нь туслах ёстой юм” гэж Төгсбэлэг хариулав.

Тэгэхэд хүүхдүүд Төгсбэлэгийг тойрч зогсоод “Бидэнд өгөх илүү нэвтрэх зөвшөөрөл чамд байгаа юу? Бид ч бас Хаантай уулзаж, түүний хаант улсад амьдрахыг хүсэж байна” гэлээ.




Төгсбэлэг инээмсэглэн “Нэвтрэх зөвшөөрлийг авахыг хүссэн хүн бүр нэг нэгийг авч болно” гээд хүүхдүүдэд нэвтрэх зөвшөөрлийг өгөхөд тэд уралдан авцгаав.




Төгсбэлэг аяллынхаа туршид олон хүнд Хаан болон түүний улсын талаар ярьсаар явав. Ихэнх хүн Төгсбэлэгийн ярьсан зүйлд итгэж Ойн цаадах хаант улсад орох зөвшөөрлийг баяр хөөр болон түүнээс хүлээн авч байсан ч зарим нь түүнийг тохуурхан шоолж байлаа.


Төгсбэлэг нэгэн өдөр хаант улсын тухай ярьж өгөх хүн хайн ойгоор явж байгаад өмнө нь огт харж байгаагүй гайхалтай нэгэн хүнтэй нүүр тулав. Тэр хүн хөлөө хүрсэн урт нөмрөгтэй, хүзүүндээ алтан шаргал ороолт зүүсэн байсан ба нүд нь галын дөл мэт гялалзаж байлаа. Төгсбэлэг түүнийг радио холбоогоор ярьсан Хаан мөн болохыг зүрх сэтгэлээрээ шууд л мэдэрчээ.


Тэрээр “Төгсбэлэг ээ!” хэмээн намуун зөөлөн хоолойгоор дуудан “Би чамайг өөрийнхөө амьдардаг газарт аваачихаар ирлээ” гэв.






Хаан гараа сунган түүнийг өөртөө ойртуулан зөөлнөөр тэврэн авав. “Чи маш олон жил миний үгийг дагаж хэдий бэрхшээлтэй байсан ч миний хүссэн замаар явж ирлээ. Чиний ойд хийх ажил дууссан болохоор одоо миний хаант улсад амьдрах цаг чинь боллоо. Харин амьдрах шинэ гэр орныг чинь үзүүлэхээсээ өмнө би чамайг нэг газар уруу дагуулж явмаар байна” гээд Хаан Төгсбэлэгийг сүр жавхлант тавцан дээр дагуулан гарав. Тэднийг тавцан дээр гармагц тэнд цугласан асар олон хүн Төгсбэлэгийн өмнө нь огт сонсож байгаагүй чангаар алга ташин угтав.









“Ноёнтон! Хүмүүс яагаад алгаа ташин баярлацгаагаад байгаа юм бэ?” хэмээн Төгсбэлэг чанга дуугаар Хаанаас асуув.

“Чамд зориулж байгаа юм, Төгсбэлэг ээ” гэж Хааныг хэлэхэд Төгсбэлэг “Яагаад надад баяр хүргэж байгаа юм бэ?” гэж гайхан асуув.

“Хаант улсын минь төлөө хийсэн бүх агуу зүйлийн чинь тухай би тэдэнд ярьж өгсөн юм. Төгсбэлэг ээ! Өөрийн шинэ гэртээ тавтай морил. Энд байгаад чинь би их баяртай байна” гэж Хаан хэлэв.



Энэ бол нэгэн
алуу туухийн
зөвхөн эхлэл юм.




ТАЙЛБАР

“Төгсбэлэгийн аялал” ном нь сургаалт зүйрлэл хэлбэрээр бичигдсэн юм. Сургаалт зүйрлэл бол Бурханы тухай үнэнийг таниулдаг богино түүх юм. Есүс сургаалт зүйрлэл ашиглан шавь нараа сургадаг байв. Яг үүнтэй адил Төгсбэлэгийн аялал нь бидэнд Бурханы тухай мэдэхэд туслана. Тиймээс Төгсбэлэгийн аялал номын гол санаа нь гэвэл:



Төгсбэлэг бол бусдын л адил жирийн хүн. Тэр тантай, бас надтай адилхан. Төгсбэлэг ширэнгэн ойн цаана орших хүчирхэг Хаант улсад очиж, Эзэн хаантай нь уулзахыг чин сэтгэлээсээ хүсдэг байсан ч хэрхэн олж уулзахаа мэдэхгүй байв. Үүний адил, хүмүүсийн зүрх сэтгэлийн гүнд Бурхантай уулзах хүсэл битүүхэн нуугдаж байдаг. Гэвч ихэнх хүн Бурханыг хэрхэн таньж мэдэж, яаж уулзахаа мэддэггүй.



Гэсэн ч Төгсбэлэг тэрхүү Хааныг олж уулзахаар шийдэж, ширэнгэн ой руу аялалд гарчээ. Гэтэл замд нь нэгэн хүн дайралдаж, Төгсбэлэгт “Тэр улсын Хаан чамтай уулзахгүй дээ. Түүнд чам шиг ийм өчүүхэн эр биш, харин зоригт дайчид л хэрэгтэй” гэжээ. Бурханы хувьд би тийм ч эрхэм чухал биш гэж боддог хүмүүс бий. Яг үнэндээ хүн бүр Бурханд нандин, үнэ цэнэтэй бөгөөд Тэр бүх хүнийг Өөрийнхөө төгс дүр төрхөөр бүтээсэн билээ.

“Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв.” Эхлэл 1:27



Төгсбэлэг мөнөөх том биетэй хүнээс салаад ой дундуур цааш явжээ. Тэрээр ойн цаана орших хүчирхэг Хаант улсад хүрэх замыг олохыг хичээн харанхуйд тэмтчиж яваад нэгэн хүнтэй санаандгүй мөргөлдчихөв. Тэр хүн ойн цаана орших хүчирхэг Хаант улс уруу нэвтрэх эрхийн бичиг хайж байлаа. Төгсбэлэг үүнд ихэд гайхдаг. Яагаад гэвэл Хаант улс уруу ороход нэвтрэх бичиг хэрэгтэй гэдгийг тэр мэдээгүй байсан. Энэ нь тэр нутгийн хууль юмсанж. Үүнчлэн Бурханд ч бас хууль бий. Тэр хуульд, Есүстэй хувьчлан харилцахгүйгээр хэн ч Тэнгэрийн хаант улсад орж чадахгүй гэсэн байдаг.

"Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй" (Иохан 14:6) гэж Есүс хэлсэн.




Тиймээс Төгсбэлэг ширэнгэн ойн цаана орших Хаант улс уруу нэвтрэх эрхийн бичгийг юуны түрүүнд гуйх хэрэгтэй болов. Бид ч бас Есүстэй харилцаатай болохын тулд Түүнийг өөрсдийнхөө зүрх сэтгэлд урин оруулах хэрэгтэй.

"Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно." Ром 10:9



Есүсийг зүрх сэтгэлдээ хүлээж авсны дараа бидэнд өөр нэг бэлэг өгөгддөг бөгөөд тэр бол Ариун Сүнс юм. Ариун Сүнсийг Төгсбэлэгийн гар чийдэнтэй зарим талаар адилтгаж болно. Ариун Сүнс биднийг хөтлөн дагуулж, явах ёстой зам, хийх ёстой зүйлсийг зааж өгдөг. Төгсбэлэг гар чийдэнтэй болохоосоо өмнө юмсыг арай ядан харж, ямар нэг юм мөргөчихгүйн тулд гараа урагш сунган тэмтчиж байв. Харин гар чийдэнтэй болсоноор хаашаа явж байгаагаа маш тодорхой хардаг болжээ. Бид Есүсийг таньж мэдсэнээр Ариун Сүнс бидний замыг мөн ийнхүү гэрэлтүүлдэг. Тэр бидний замыг зааж өгдөг.




"Харин үнэний Сүнс болох Тэр ирэхдээ та нарыг бүх үнэн уруу удирдана..." (Иохан 16:13)

Цааш явж байтал модон дээрээс нэгэн амьтан Төгсбэлэгт хандан, гар чийдэнгээ унтраа гэх нь сонсдов. Төгсбэлэг түүний хэн болохыг харахаар тэр зүгт эргэн, мод уруу гэрлээ тусгатал өнөөх амьтан нисээд явчихаж гэнэ. Тэр амьтан гэрлээс айдаг аж. Муу ёрын сүнс/диавол/ энэ амьтантай адилхан бас гэрлээс айдаг. Муу ёрын сүнс бол Бурханы дайсан. Тэр биднийг Бурханы замаас холдуулж, төөрүүлэхийг хүсдэг. Тэр биднийг Бурханы дууг сонсохоо болиосой гэж хүсдэг. Гэвч, хэрэв бид Бурханыг сонсож, Ариун Сүнсний удирдамжийг дагасаар байх юм бол тэр бидэнд ямар ч хор хүргэж чадахгүй. Бид муу ёрын сүнсийг Есүсийн нэрээр эсэргүүцвэл тэр биднийг орхихоос өөр замгүй болдог.




"Бурханд ойрт. Бугийг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна." Иаков 4:7


Энэ ширэнгэн ойд айдас төрүүлэм элдэв амьтад, төөрч будилмаар олон нарийхан зам байсан хэдий ч энэ бүхнээс айж сүрдэх шаардлага Төгсбэлэгт огтхон ч байсангүй. Учир нь гар чийдэн нь түүний замыг гэрэлтүүлж, удирдан хөтөлж байлаа. Мөн түүнд нэг сэлэм байв. Бидэнд ч мөн сэлэм байдаг. Бидний сэлэм бол Библи юм. Библи нь тэр чигээрээ Бурханы үг билээ. Библи дээрх үг бүхэн үнэн.



"Шавар зууханд тунгаагдаж, долоо дахин цэвэршүүлэгдсэн мөнгө мэт ЭЗЭНий үг бол цэвэр юм." Дуулал 12:6

Хэрвээ та библийг уншин судлах цаг гаргавал Есүс танд амьдралын мэргэн ухаан, сайн сайхныг таниулах болно








Түүнчлэн Төгсбэлэг Хаантай ярилцах радио холбоотой болжээ. Тэрхүү төхөөрөмжид асааж, унтраах товчлуур байхгүй, үргэлж асаалттай байдаг аж. Төгсбэлэг өдөр, шөнө ялгаагүй хүссэн үедээ Хаантай ярилцах боломжтой байв. Бид ч мөн адил ямар ч үед Бурхантай ярих боломжтой. Түүнтэй ярьмаар санагдсан үедээ зүгээр залбирахад л хангалттай. Залбирал маш хүчтэй. Залбирал гэдэг нь өөрөөсөө агуу нэгэнд итгэлээ даатгах гэсэн утгатай. Тиймээс залбирлаар дамжуулан Бурхан ажлаа хийдэг. Ямар ч үед залбирахдаа Бурхан бидний залбиралд хариулна гэдэгт итгэлтэй байх хэрэгтэй. Бид итгэлтэйгээр залбирах үедээ гуйсан зүйлээ хүлээн авдаг.

"Та нар итгэлтэйгээр залбиран гуйсан бүх зүйлсээ хүлээн авах болно гэж айлдав." Матай 21:22



Төгсбэлэгийг ширэнгэн ойн цаана орших Хаант улсад нэвтрэх эрхийн бичгээ хүлээж аваад, тэр даруй орох гэтэл Хаан түүнийг орохыг зөвшөөрсөнгүй. Учир нь Төгсбэлэгийг өөрийнх нь Хаант улсын тухай бусад хүмүүст ярьж, тийш нэвтрэх эрхийн бичгийг хэрхэн авах талаар тайлбарлаж өгөхийг хүсжээ. Бурхан энэ Хаантай адилхан биднийг Есүсийн тухай сайн мэдээг хүмүүст ярьж, мөнх амийг хүлээн авах боломжийг тэдэнд олгоосой гэж хүсдэг. Есүс тэнгэр өөд явахынхаа өмнө, Өөрийнх нь тухай хүн бүрд ярьж өгөхийг шавь нартаа тушаасан байдаг. Тэрээр тэнгэрт одохын өмнө ингэж хэлсэн.




"Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгоцтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав." *Матай 28:19, 20*



Бурхан хүн бүрд хайртай бөгөөд Өөрийнх нь хайрын тухай үнэнд хүн бүрийг итгээсэй гэж хүсдэг. Харин энэхүү үнэнд итгэхэд саад болдог зүйл бол гэм нүгэл юм. Хүмүүс бие биенээ хайрлая гэдэг боловч хайрлаж чаддаггүй. Худал хэлэх нь буруу гэж боддог хирнээ худлаа ярьдаг. Бие биенийгээ хуурах нь тийм ч буруу гэж боддоггүй. Эцэг эхээ хүндэлдэггүй, үгийг нь дагадаггүй. Нэг нэгийгээ хараан доромжилж, буруутган яллаж, үзэн яддаг. Эдгээр үйлдэл гэм нүгэлд тооцогддог. Ийм л учраас Бурхан гэм нүглээс хүмүүсийг чөлөөлж, аврахын тулд Есүсийг загалмай дээр нас барахыг зөвшөөрсөн. Тэр хүмүүсийн төлөө амиа өгсөн боловч Бурхан Түүнийг үхлээс амилуулж, улмаар хүмүүст мөнх амийг бэлэг болгон өгсөн. Энэ сайхан мэдээг хүмүүст хүргэх нь чухал юм. Хэрвээ хүн чин сэтгэлээсээ Есүсийг өөрийн Аврагч Эзэн хэмээн хүлээн зөвшөөрч, итгэвэл энэхүү бэлгийг авах болно.


“Цорын Ганц Үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн.” Иохан17:3

Эцэст нь нэг өдөр Төгсбэлэг мөнөөх Хаантай нүүр нүүрээрээ уулзжээ. Хийх ёстой ажил чинь дууссан гэж Хаан түүнд хэлээд, Төгсбэлэгийг ширэнгэн ойн цаана орших Хаант улсдаа урьжээ. Үүний адил, Есүсийг өөрийн Аврагч бөгөөд Эзэн хэмээн хүлээн зөвшөөрч итгэсэн хүн бүр хэзээ нэгэн өдөр Түүнтэй хамт мөнхөд амьдрах болно гэж Библид амласан байдаг. Та нар Бурханд таалагдах гэж чин зүрхнээсээ хүсэн тэмүүлснийхээ хариуд энэ дэлхий дээр байхдаа төдийгүй тэнгэрийн улсад очсон хойноо шагнал авах болно.



Бурханыг таньж мэддэг хүмүүст олон сайхан зүйлс төлөвлөгдсөн байдаг. Гэвч хэн нэгэн нь Есүс Христийг өөрийн Аврагч хэмээн хүлээн аваагүй бол тэдгээр сайхан зүйлсээс хүртэж чадахгүйд хүрнэ. Есүстэй хувьчлан уулзсан хүмүүс Бурханы төлөвлөгөөний талаар илүү ихийг олж мэддэг. Хэрэв та Түүнтэй хараахан уулзаагүй байгаа бол яг одоо цаг гаргаад, Түүнээс гуйж болно. Тэр бол мөнх аминд хүрэх цорын ганц зам бөгөөд зөвхөн Түүгээр дамжуулан мөнх амийг авах боломжтой. Хэрвээ та Есүсийг өөрийн Аврагч болгон хүлээж авахыг хүсвэл дараах залбирлыг хийж болно.

Бурхан минь, намайг үргэлж хайрлаж байдаг гэдгийг мэдүүлсэнд баярлалаа. Есүс миний төлөө загалмай дээр нас барсан гэдэгт болон Тэрээр үхлээс амилуулагдаж, одоо тэнгэрийн улсад Тантай хамт байгаа гэдэгт би итгэж байна. Таны надад бэлэглэж байгаа мөнх амийг би хүлээн авч, үүний төлөө Танд талархаж байна.
Би өөрийнхөө бүх амьдралыг
Танд даатгаж, үргэлж
Тантай хамт алхахыг хүсэж байна.
Амен.





HANDS to the PLOW
MINISTRIES

handstotheplow.org